



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/159

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн урьдчилгаа төлбөрт Маргад ложистик ХХК-д 20.000.000 (хорин сая) төгрөгийг олгосугай.

2. Дээрх 20.000.000 (хорин сая) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

3. Урьдчилгаа төлбөрт олгогдсон санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас суутгахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаярт)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100343